

ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг
торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай
хуулийн төслийн талаар

Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахал дэгдэж, хүн амын дунд өвчний тохиолдол гарсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, цар тахлын үед бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд эрчим хүчээр хангах, хүнсний үйлдвэрлэл, худалдаа, түгээлтийн үйл ажиллагаа, газрын тосны бүтээгдэхүүн, түлшний хангамж, түгээлт, тээвэрлэлтийн болон хот, суурины усан хангамж зэрэг 18 чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагаас бусад байгууллагуудын үйл ажиллагааг зогсоосон. Дийлэнх байгууллагын үйл ажиллагааг зогсоосноор аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бизнесийн үйл ажиллагаа доголдож, орлого буурч, нийгмийн даатгалын шимтгэлээ хугацаанд нь төлж чадахгүй байх нөхцөл үүсээд байна.

Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 183 дугаар тогтоол батлагдсан бөгөөд уг тогтооолоор хуульд заасны дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн ногдуулж, тайлагнасан боловч төлөгдөөгүй нийгмийн даатгалын шимтгэлд тооцох алданги, торгуулиас хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагыг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд чөлөөлөх хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд нэн яаралтай өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу уг хуулийн төслийг боловсруулсан болно.

Иймд Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг тургох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулж, дээрх тогтоолд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийг ногдуулж тайлагнасан боловч шимтгэл төлөөгүй ажил олгогч, даатгуулагчийг Зөрчлийн тухай хуульд заасан тургох шийтгэл, алдангиас чөлөөлөхөөр тусгасан.

Энэхүү хуулийн тесөл батлагдсанаар нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангаа үнэн, зөв мэдүүлэн ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний бизнесийн үйл ажиллагаанд санхүүгийн дарамт нэмж учруулахгүй байх нөхцөл бүрдэх бөгөөд уг хуулийн үйлчлэлд 10.0 мянга орчим аж ахуйн нэгж, байгууллага 30.0 тэрбум төгрөгийн тургох шийтгэл, алдангиас чөлөөлөгдөх урьдчилсан тооцоо хийгдсэн болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР